

Эдийн засагт авлигын үзүүлэх сөрөг нөлөө

Дамдинсүрэнгийн Ууганжаргал, докторант

Монгол Улсын Их Сургууль, Бодлогын судалгааны лаборатори

Улаанбаатар, Монгол Улс, Холбоо барих зохиолч: uuganjatgal.d@num.edu.mn

Хүрэлбаатарын Анхбилэг, докторант

Монгол Улсын Их Сургууль, Бодлогын судалгааны лаборатори

Улаанбаатар, Монгол Улс, ankhbileg.kh@num.edu.mn

<https://orcid.org/0009-0006-9984-6453>

Article history

Received : 2025-08-31

Accepted : 2025-11-30

Published : 2025-12-31

Түлхүүр үгс

Монгол Улс, эдийн засгийн өсөлт, авлига, авлигын индекс

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Монгол Улсын авлигын одоогийн нөхцөл байдал, тэр нь ялангуяа эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлохыг зорьсон бөгөөд үүний тулд эконометрик загварт тулгуурлан эмпирик шинжилгээг хийж, авлига байхгүй тохиолдолд тус улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) дунджаар 23 хувиар өсөх боломжтойг харуулсан. Түүнчлэн засаглалын ил тод байдал, баялгийн шударга хуваарилалт болон авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн бодлогын зөвлөмжийг тусгав.

Negative effects of corruption on the economy

Ууганжаргал Дамдинсүрэн, doctor candidate

National University of Mongolia, Policy Research Laboratory

Ulaanbaatar Mongolia, Corresponding author: uuganjatgal.d@num.edu.mn

Ankhbileg Khurelbaatar, doctor candidate

Policy Research Laboratory, National University of Mongolia,

Ulaanbaatar, Mongolia, ankhbileg.kh@num.edu.mn

<https://orcid.org/0009-0006-9984-6453>

Keywords

Mongolia, economic growth, corruption, corruption index

© The Author(s), 2025



Abstract: This study aims to assess the current state of corruption in Mongolia and its impact on the economy, focusing particularly on its effect on economic growth. Using an econometric model, the empirical analysis reveals that in the absence of corruption, Mongolia's Gross Domestic Product (GDP) could increase by an average of 23%. The study also provides policy recommendations to enhance transparency in governance, ensure equitable distribution of natural resources, and strengthen anti-corruption measures.

I.УДИРТГАЛ

Байгалийн баялаг ихтэй, хөгжиж буй эдийн засагтай Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжилд авлигын үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах асуудал онцгой ач холбогдолтой юм. Ардчилсан улс төрийн систем, олон намын тогтолцоо, чөлөөт нээлттэй, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг үндсэн хуулиараа иргэддээ олгосон манай улс нь сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагуудаас гаргадаг авлигын үзүүлэлтээр улс орнуудыг эрэмбэлсэн индексээр тогтмол ухарч байгаа нь судлаачдын анхаарал татаж байна.

Засаглалын сул дорой байдал, улс төрийн намуудын төлөвшил, нийгмийн оролцогч талуудын идэвхгүй оролцоо, эрх зүйн ойлгомжгүй орчин, эдийн засгийн тодорхой бус байдал, соёл, итгэл үнэмшил зэргээс үүдэн авлига нийгэмд цэцэглэн хөгжиж, тархдаг хэмээх олон улсын судалгааны үр дүн ч Монголд биеллээ олсон гэж хэлж болохоор байна. Тиймээс олон улсын болон дотоодын судлаачдын авлига, эдийн засгийн хөгжлийн талаарх судалгааны үр дүнг судлан, олон улсын панел тоон өгөгдөл, Монгол Улсын холбогдох үзүүлэлтүүдэд эконометрикийн шинжилгээ хийж үр дүнг тооцоолов.

Байгалийн баялгийн менежментгүй байдал, шударга бус хуваарилалт нь авлигын эрсдэлд өртөх магадлалыг нэмэгдүүлж байна. Энэ нь эдийн засгийн орлогын тэгш бус хуваарилалт, ядуурал, нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлдэг (OECD, 2018). Түүнчлэн, авлига нь улсын хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад саад учруулаад зогсохгүй хөгжлийн хэтийн зорилгод хүрэх боломжийг хязгаарладаг (Kaufmann & Kraay, 2019). Авлига нь улс орны хөгжлийг сааруулж, төрийн удирдлагын менежмент, үр ашигт байдал, хөрөнгө оруулалтын орчин, нийгмийн бүхий л хүрээнд сөрөг нөлөө

үзүүлдэг. Тиймээс авлигын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судлах нь ирээдүйн хөгжлийн бодлого боловсруулж, бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үндэслэл болдог.

Авлигын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох судалгааг Монгол Улсын нөхцөлд судалж, зөвлөмж боловсруулах нь хэд хэдэн шалтгаантай. (I) Авлига нь эдийн засгийн өсөлт, хөгжлийг удаашруулдаг гол хүчин зүйлсийн нэг гэж үздэг. Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн (IMF) судалгаанаас үзэхэд авлигын өндөр түвшинтэй улс орнуудад хөрөнгө оруулалт буурах, бизнесийн зардал нэмэгдэх, нийгмийн тэгш бус байдал гүнзгийрэх хандлага ажиглагддаг (Bank, 2020; Fund, 2019). Монгол Улсад эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад авлигатай тэмцэх нь зайлшгүй шаардлагатай болж байна. (II) Авлигын улмаас засаглалын чанар болон төрийн үйлчилгээний хүртээмж сулрах, төсвийн хөрөнгийн үр ашиг буурах эрсдэлтэй. Монгол Улсын хувьд, ялангуяа байгалийн баялгийн орлогыг зохистой зарцуулах нь нийгмийн сайн сайхан байдлыг хангах чухал хүчин зүйл юм. Гэвч авлига нь энэ үйл явцыг сааруулж, баялгийн шударга бус хуваарилалт, нийгмийн итгэлцлийг алдагдуулахад хүргэж байна (International, 2022)


(III) Авлигын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг тооцоолох судалгаа нь бодлого боловсруулагчдад шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлдэг. Монгол Улсын хувьд авлигын түвшин, түүний эдийн засагт үзүүлж буй нөлөөг бодитоор тооцоолох замаар төрийн бодлого, хууль эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх боломжтой. Жишээ нь, “МакКензи”-ийн судалгаанд дурдсанаар авлигын үр нөлөөг бууруулснаар ДНБ-ий 2-5 хувийн

өсөлтийг бий болгох боломжтой гэж үздэг (Companu, 2018).

Транспаренси Интернэшнл (Transparency International, 2023) байгууллагын судалгаагаар Монгол Улс нь авлигын индексээрээ дэлхийд дунджаас доогуур үнэлгээтэй байна. Энэ нь улсын хэмжээнд бизнесийн орчинд итгэлцлийг алдагдуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахад

саад болж буй гол шалтгааны нэг юм. Авлига нь төсвийн зардлын ил тод байдал, үр ашигт сөргөөр нөлөөлж, нийгмийн үйлчилгээний чанарыг бууруулдаг байна (Bank, 2020). Тус онд манай орны талаарх авлигын төсөөллийн индексийн утга өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөгдөөгүй байна (Зураг 1).

Зураг 4. Монгол Улсын авлигын индекс 2023



Эх сурвалж: Транспаренси Интернэшнл (Transparency International)

Монгол Улсын авлигын төсөөллийн индекс болон дэлхийн улс орнуудын дунд эзэлж буй байр (ранк) өөрчлөлтийг 2012-2023 оны утгуудаар харьцуулан судлав. Уг индекс нь тухайн улсын авлигын түвшнийг хэмждэг гол үзүүлэлт бөгөөд индекс өндөр байх нь авлигын түвшин бага байгааг, харин индекс бага байгаа нь авлигын түвшин өндөр байгааг илэрхийлдэг. (Зураг 2)

2012 онд Монгол Улсын авлигын индекс 36 байсан бол 2023 онд 33 болж буурсан байна. Энэ хугацаан дахь индексийн өөрчлөлтөөс харахад 2015 он хүртэл бага зэргийн өсөлт ажиглагдсан


боловч 2017 оноос эхлэн тасралтгүй буурсан байна. Энэ нь манай орон авлигын эсрэг бодлогыг тогтолцооны хувьд хэрэгжүүлж чадаагүйг харуулж байна. Дэлхийн улс орнуудын дунд эзлэх байр нь 2012 онд 94 байсан бол 2023 онд 121 болж, доошилсон. Энэ нь Монгол Улсын авлигын түвшин дэлхийн бусад улс орны түвшинтэй харьцуулахад илүү сул байгааг харуулж байна. Нөгөөтэйгүүр, Монгол Улсын эдийн засаг, институтийн хөгжилд сөргөөр нөлөөлж байгааг харж болно. Тухайлбал, 2017 оноос хойш индекс бууралттай байгаа нь төрийн байгууллагуудын

хариуцлагын тогтолцоо сул байгаатай холбоотой байж болох юм. Авлигын индекс доошилж буй нь дотоодын хүчин зүйлээс гадна бусад улс орны авлигын эсрэг бодлого илүү үр дүнтэй хэрэгжиж байгаагийн илрэл гэж үзэж болно.

Авлигын өндөр түвшин нь эдийн засгийн өсөлтийг удаашруулах, хөрөнгө оруулалтыг бууруулах, төрийн үйлчилгээг үр ашиггүй болгох зэрэг олон сөрөг үр дагавартай. Энэ нь олон улсын судалгаагаар нотлогдсон байдаг.

Жишээлбэл, авлига хөрөнгө оруулалтыг бууруулснаар эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг, институтийн чанарыг алдагдуулж, хувийн секторын хөгжилд саад учруулдаг хэмээх дүгнэлтийг олон улсын эмпирик судалгаанууд нотолдог.

Зураг 5. Монгол Улсын авлигын төсөөллийн индекс (2012-2023)



Эх сурвалж: Transparency International

II. СЭДВИЙН СУДАЛГДСАН БАЙДАЛ

Монгол Улсын авлигын өнөөгийн нөхцөл байдал, түүний эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тооцох судалгаа нь авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлэх, бодлогын хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх, олон улстай хийх худалдаа, эдийн засгийн харилцааг сайжруулахад бодит хувь нэмэр оруулах юм. Судалгаа нь онол, практикийн хувьд ач холбогдолтой бөгөөд урт хугацааны эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үндэс суурийг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

Авлига нь дэлхийн ихэнх улс орнуудад эдийн засгийн хөгжлийг сааруулах, нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх, институтийн итгэлцлийг алдагдуулах сөрөг нөлөөтэй болохыг доорх судалгаануудад дурджээ. Авлигыг бууруулах бодлого боловсруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих арга замыг тодорхойлоход энэ чиглэлийн судалгаанууд хувь нэмрээ оруулсаар ирсэн.

| № | Судалгааны ажлын нэр | Гол үр дүн | Эх сурвалж |
|---|---|--|-----------------------------|
| 1 | Монгол Улсын Авлигын байдалд хийсэн үнэлгээ | <p>-Бараг бүх шатанд ашиг сонирхлын зөрчилдөөн тодорхой салбар болон системийг бүхэлд нь хамарсан шинжтэй болсноор улсын ба хувийн хэвшлийн хоорондох зааг хязгаар нэлээд бүдгэрсэн.</p> <p>-Иргэдэд үзүүлэх үйлчилгээ хүрэлцээ муутай байгаа нь хэт улс төржсөн төр захиргааны байгууллагуудыг нэмэгдүүлж, “бялуу хуваах систем” (<i>Re-slicing the pie of patronage</i>) оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>-Монгол банк, Үндэсний аудитын газар, УИХ-ын байнгын хороод, Ерөнхий прокурорын газар, Улсын мэргэжлийн хяналтын газар, Төрийн өмчийн хороо болон Сангийн яамны хэлтэс, газрууд зэрэг төр засгийн хяналтын институтууд сул байна.</p> | (Casals & Associates, 2005) |
| 2 | Монгол дахь авлигын түвшинд нөлөөлөгч хүчин зүйлс: баримт бичгийн ба тоон судалгааны анализ | <p>500 гаруй хүнийг хамарсан тоон судалгаа, 4 фокус группэд хуваагдсан 32 оролцогчид чанарын судалгаа хийсэн. Авлигыг илрүүлэх ёстой байгууллага нь өөрөө авлигад идэгдсэн гэж 26.4%, албан тушаалтнуудад хууль үйлчилдэггүй тогтолцоо хэвшмэл болсон гэж 25.6% нь үзэж байгаа нь нийт оролцогчдын 52.0% байна. Уг судалгаанд “та өөрөө авлигал өгөх тохиолдол гарч байсан байгууллагыг нэрлэнэ үү” гэсэн асуултад нийт оролцогчдын 28.4% нь хууль сахиулах байгууллагад гэж хариулсан байна.</p> | (Ж.Төртогтох et al., 2007) |
| 3 | Монгол улс дахь авлигын шалтгаан ба үр дагаврууд | <p>Монгол дахь авлига үүсэх шалтгааныг судалж гаргах зорилготойгоор тус ажил хийгджээ. Авлигад хамгийн ихээр улс төрийн элит хэсэг өртөж байгааг тогтоож, эдийн засгийн өсөлт, ардчиллын үнэт зүйлд сөрөг нөлөөтэй байгааг тогтоожээ. Мөн байгалийн баялаг, асуудлаа шийдүүлэх хүсэлтэй хувийн хэвшил, орлогын бага байдал, шударга бус хуулийн тогтолцоо, төрийн албаны хүнд суртал зэрэг нь Монголд авлигыг өдөөх үзүүлэлтүүд болж байгааг тогтоожээ.</p> | (Б.Ариун-Эрдэнэ, 2008) |
| 4 | Монгол улсын авлигыг хэмжих оролдлогууд ба монголын авлигын индексийн судалгаа, түүний ач холбогдол | <p>Тус судалгааны ажилд Монгол Улсын 9 аймгийн 30 сумын оршин суугчид нийт 2000 гаруй хүн хамрагдсаны дотор 1508 хүнээс анкетаар, 306 хүнээс стандарт сурвалжилгаар, 200 гаруй хүнээс чөлөөт сурвалжлагын аргаар асуулга авч аймгуудын авлигын индексийг 2009 оны инфляцын түвшин, авлигын бүртгэгдсэн гэмт хэргийн тоо зэргийн хамаарлыг тооцсон байна. Инфляцын түвшнийг 1 хувиар нэмэгдүүлэхэд авлигын индекс дунджаар 0.0009-ээр буурна, өөрөөр хэлбэл авлигад өртөх эрсдэлийг нэмэгдүүлнэ хэмээн үзжээ. Мөн авлигын индексийг ядуурлын хамрах хүрээ болон бүртгэгдсэн авлигын гэмт хэрэгтэй хамааруулснаар авч үзвэл ядуурлын түвшин нэг хувиар нэмэгдэхэд авлигын индекс 0.24-өөр, авлигын бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэг нэгжээр нэмэгдэхэд авлигын индекс 0.0003-аар буурсан гэх үр дүнг гаргажээ.</p> | (Д.Жаргалан, 2011) |

| | | | |
|---|---|--|---|
| 5 | <p>Авлигын эсрэг НҮБ-н конвенцын II бүлгийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах нь</p> | <p>-Монгол Улс авлигаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгож, эрх зүйн орчны хувьд авлигын шаардлагыг хангах чиглэлд төр засгийн зүгээс дорвитой алхмууд хийгдсэн гэж үзжээ. Харин авлигаас сэргийлэх, тэдгээртэй холбогдох хуулиудын хэрэгжилтийг хангах талаар бүх оролцогч талуудын анхаарлыг хандуулж, үйл ажиллагааны уялдаа холбоо бүхий төрийн байгууллагуудын үндэсний, бүс нутгийн, олон улсын хэмжээний хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлэх нь зүйтэй байна.</p> <p>-Мэдээллийн технологийн өндөр хөгжлийн үед цахим хуудсаараа үйл ажиллагаагаа ил тод болгож, олон нийтэд 24 цагийн турш тайлагнах бодит орчин бүрдсэн байна. Энэхүү таатай орчин нь төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллага ашиглан авлигаас урьдчилан сэргийлэх, зохистой засаглалыг хөгжүүлэх гол хэрэгслээ болгож дадах нь чухал байна.</p> | <p>(UNDP, 2014)</p> |
| 6 | <p>Авлигын хандлагын судалгаа</p> | <p>-Судалгаанд хамрагдсан иргэдийн үнэлгээгээр авлигад хамгийн өртөмтгий байгууллагуудаар “Эрдэнэт үйлдвэр” ХХК, Цагдаагийн газар, Шүүх, Эрүүл мэндийн Газар, Прокурорын байгууллага, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд, Гаалийн газар зэргийг нэрлэсэн байна.</p> <p>-Судалгаанд авлига өгсөн гэж хариулсан хүн амын 52% нь 2 буюу түүнээс олон удаа авлига өгч байсан гэжээ.</p> <p>-Судалгаанд хамрагдсан хүн амын ихэнх нь буюу 72.2% нь удирдах болон гүйцэтгэх албан тушаалтанд авлига өгсөн гэж хариулжээ. Авлигыг ихэвчлэн мөнгөн хэлбэрээр өгдөг байна.</p> <p>-Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 58.1% нь авлигын талаар мэдээлэл өгөх эрмэлзэлтэй байхад, 49.1% нь авлигын талаар мэдээлэл өгөх эрмэлзэлгүй гэж хариулжээ..</p> | <p>(МУИС-ийн Орхон салбар сургууль, 2014)</p> |
| 7 | <p>Авлига болон хүнд суртлын орлого хуваарилалтад үзүүлэх нөлөө</p> | <p>Авлига болон хүнд суртал нь хөрөнгө оруулалт хийх боломж болон мэргэжлийн сонголтод нөлөөлөх замаар орлогын тэгш бус байдлыг хэрхэн бий болгож болохыг харуулсан байна. Эдийн засагт хоёр төрлийн төгс бус байдал байдаг хэмээгээд нэг нь санхүүгийн зах зээлийн төгс бус байдал буюу зээлдэгч гэрээний нөхцөлийг төгс гүйцэтгэх боломжгүй байдлаас үүсэж буй нөхцөл. Хоёр дахь нь төрийн албан хаагчдын зүгээс рент эрэлхийлэх (хахууль авах) боломж үүсгэж буй засаглалын төгс бус байдал. Төрийн хүнд суртлын үйл ажиллагааг рент эрэлхийлэгчид тодорхойлдог хахуулийн түвшнийг хамгийн их байлгах хүнд суртлыг бий болгох нь орлого хуваарилалт болон нийт үйлдвэрлэлд хэрхэн нөлөөлөхийг харуулсан ажил болжээ.</p> | <p>(Б.Соёлмаа, 2019)</p> |

Монгол Улсад авлигын чиглэлээр хийгдсэн дээр дурдагдсан томоохон судалгаанаас гадна төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд уул уурхай, эрүүл мэнд, улс төр болон хууль, эрхзүйн салбаруудын түвшинд нарийвчилсан чанарын болон тоон эмпирик судалгаанууд олон хийгджээ.

Гадаадад судлагдсан байдал

Авлига эдийн засгийн өсөлтийг дэмждэг үү, эсвэл сааруулдаг уу?

Дугуйг элсэнд гацаах (Sand the wheels hypothesis) таамаглалын дагуу авлига нь засаглал сул хөгжсөн орнуудад эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлж болно гэж үздэг (Kato Sato T., 2015). Энэхүү үзэл баримтлалыг дэмжигчид авлигын орчинд хахууль нь төрийн хүнд сурталтай орчинд үйл явцыг хурдасгаж чадна гэж үздэг (Huntington, 2006; Leff, 1964). Гэвч тус судалгаа нь авлига ба төрийн хүнд суртал нь хоорондоо салшгүй холбоотой гэдэг нийтлэг онолын тайлбарт ач холбогдол өгөөгүй, харин төрийн албан хаагчид хахууль авахын тулд санаатайгаар саатал үүсгэх нь хүнд суртлыг улам нэмэгдүүлдэг хэмээн үзсэн. (Lui, 1985).

Aidt (2009) нар дээрх таамаглалыг батлах эмпирик үр дүн сул байгааг харуулж, нэг хүнд ногдох баялгийн хэмжээ ба авлигын хооронд хүчтэй сөрөг хамаарал байдгийг онцолсон. Харин Coogay & Schneider F., (2018) нар уг таамаглалыг дэмжиж, авлига эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй гэж үзсэн.

Авлига нь ихэвчлэн нөөцийн хамгийн үр ашигтай зарцуулалтыг алдагдуулах замаар эдийн засгийн өсөлтийг саатуулдаг (Murphy Shleifer A. Vishny R., 1991, 1993). Авлигын улмаас бизнес эрхлэгчид үр ашиг багатай, албан бус салбарыг сонгох хандлагатай болдог (Antunes Cavalcanti T., 2003). Нэмж дурдахад, авлига нь үр ашиггүй, богино хугацааны бизнесийн зан үйлийг дэмждэг (Choi & Thum, 2004; Svensson, 2003). Mauro (1995) нар нь авлига хөрөнгө оруулалтыг бууруулснаар эдийн

засгийн өсөлтөд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг болохыг тогтоосон. Pellegrini Gerlagh R., (2004) нар хувийн секторын хөгжил болон институтийн чанарыг алдагдуулдаг авлигын гажуудуулах нөлөөг онцлон тэмдэглэсэн байна.

Blackburn et al., (2006) болон Blackburn Powell J., (2011) нар авлигын өсөлтөд үзүүлэх нөлөөг загварчилж, эдийн засгийн хөгжил ба авлигын хооронд ихээхэн сөрөг хамааралтай болохыг харуулсан. Авлигын тогтворжилтын тухайд Вацао болон бусад (2019) болон Fargooq et al., (2013) нар нь урт хугацааны нөлөөг VAR загвар ашиглан судалсан бол Nееmес et al., (2021) нар DSGE загвар ашиглан авлига хэрхэн албан бус секторыг дэмждэгийг харуулсан. Бид энэхүү судалгаагаар тэдгээр загваруудыг өргөтгөн, авлигаас нөлөөлсөн макро эдийн засгийн хувьсагчдын динамик тохируулгыг шинжилсэн.

Авлигын тухай ойлголт, онол арга зүй
Авлига гэсэн нэр томъёо нь (*“Corruption”* хэмээх англи нэр үг) шударга бус, хээл хахууль авдаг, ёс суртахуунгүй, зан чанар нь эвдэрсэн, ялзарсан байдал гэсэн утгатай. Харин Монгол хэлний утга зүй талаасаа *“Өөрийн ажлыг бүтээхийн тулд холбогдох албан тушаалтанд ил, далд өгөх хахууль”* (УИХ, 2006; ШУА-Хэл зохиолын хүрээлэн, 2015). хэмээн тодорхойлсон бол Авлигын эсрэг хуульд *“Албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил”* хэмээн тайлбарласан байдаг.

Авлига нь нийгмийн хөгжлийн олон шалтгааны улмаас үүсдэг. Үүнд:

- Гүйцэтгэх засаглалын сул дорой байдал
- Сонгуулийн санхүүжилтийн ил тод бус орчин
- Улс төрийн намуудын ашиг сонирхлын зөрчил

- Ядуурал, орлогын тэгш бус байдал
- Цалин хөлсний доогуур түвшин
- Эдийн засгийн зохицуулалтын ил тод бус байдал
- Зах зээлийн өрсөлдөөнгүй, монопол эрх
- Ёс зүйн боловсролын дутагдал
- Соёлын түвшинд авлигыг хүлээн зөвшөөрдөг хандлага
- Олон нийтэд мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал байх
- Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн сул хөгжил
- Авлигатай тэмцэх хууль, тогтолцооны сул түвшин
- Хууль сахиулах байгууллагуудын авлигад автагдсан байдал
- Шүүх засаглалын хараат байдал
- Авлигын хэрэгт хатуу хариуцлага ногдуулдаггүй тогтолцоо
- Албан тушаалтнуудын хяналтгүй эрх мэдэл
- Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод бус байдал
- Албан тушаалтны шийдвэр гаргах үйл явц удаан, төвөгтэй байх
- Эдийн засгийн шилжилтийн үеийн зохицуулалтын орчин
- Төрийн өмч хувьчлалын үйл явцад ил тод бус байдал зэрэг олон шалтгаан бий хэмээн судлаачид үздэг.

Авлигын талаар Монгол Улсад мөрдөгдөж буй эрх зүйн баримтуудын хувьд:

1. Авлигын эсрэг хууль
2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
3. Эрүүгийн хууль
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль
5. Төрийн албаны тухай хууль
6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай
7. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц
8. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг эрх зүйн актууд үйлчилж байна.

Эдгээр эрх зүйн актуудад авлигын тухай холбогдох хуулийн ойлголт, үзэл баримтлал, дагаж мөрдөх хэм хэмжээ, зөвшөөрсөн болон эс зөвшөөрсөн үйлдэл, эс үйлдэл, түүнээс үүсэх хор уршиг, авах арга хэмжээ, хүлээлгэх хариуцлага, ял шийтгэл, олон улсын актын дагуу дагаж мөрдөх асуудлууд зэрэг өргөн цар хүрээг хамарсан байдаг.

Тус судалгаагаар төрийн санхүүгийн удирдлагын (Public finance management) үүднээс эдийн засагт авлигын үзүүлэх нөлөөг үнэлэх өсөлтийн загварыг ашиглаж параметрийн үнэлгээ хийсэн. Авлига нь төрийн санхүүгийн нөөцийг хорогдуулж, улмаар нөөцийн алдагдалд хүргэдэг. Компаниуд авлигад зардал гаргаснаар санхүүгийн алдагдалд ордог бөгөөд энэ нь дотоод өсөлтийн загвараар тодорхойлогддог. Энэхүү авлигад гаргаж буй зардал хувийн секторт сөргөөр нөлөөлж, “*дугуйг элсэнд гацаах*” (*sand the wheels hypothesis*¹) таамаглалтай нийцдэг. Өрхүүдийг хувийн болон төрийн салбарт ажилладаг иргэд бүрдүүлдэг бөгөөд төрийн албан

¹ Энэхүү ойлголт нь авлига эдийн засгийн үр ашиг болон өсөлтөд саад тотгор учруулдаг гэсэн онол юм. Тус таамаглалын дагуу авлигыг машины араа шүдэнд элсэн ширхэг шиг үрэлт үүсгэж, ажиллах явцыг удаашруулан үр дүнгүй болгож буйгаар төсөөлдөг. Авлига нь хэлцлийн зардлыг нэмэгдүүлэх, засгийн газрын үйл ажиллагааны нэмэлт зардал гаргах нийгмийн алдагдал, хөрөнгө оруулалтыг саатуулах, мөн нөөцийг зөв хуваарилах явцыг алдагдуулах замаар эдийн засгийн

үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлдөг. Авлигын судалгаанд энэхүү таамаглал нь “дугуйг тослох” (*grease the wheels hypothesis*) таамаглалтай харьцуулагддаг. “*дугуйг тослох*” нь заримдаа авлига нь удаан, үр дүнгүй төрийн системийг тойрч эдийн засгийн үйл ажиллагааг хурдасгадаг гэж үздэг. Гэвч олон улсын судалгаануудын ихэнх нь “*дугуйг элсэнд гацуулах*” онолыг урт хугацаанд болон ялангуяа бага болон дунд орлоготой орнуудад илүү бодитой болохыг баталдаг.

хаагчид татварын орлогыг завших замаар нэмэлт орлого олдог хэдий ч уг үйлдэл нь нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах ёстой байсан хөрөнгийг бууруулж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлдэг.

Бид авлигын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцохдоо гарцын үйлдвэрийн функцийг ашигласан болно. Эдийн засаг дахь авлигын хэмжээ нь $\eta \in [0,1]$ байна. Энэ нь гарцыг $f(\eta)$ хувь хэмжээгээр бууруулна. Уг функцийн чанар нь $f(\eta)' > 0, f(\eta)'' < 0, f(0) = 0, f(1) = 1$ байна. Уг функц нь $f(\eta) = 1 - e^{(-\eta/i)}$ – гэж таамаглана (Arbex et al., 2025). Энд i нь тохируулгын параметр болно.

Гарцын үйлдвэрлэлийн функц нь,

$$Y_t = (1 - f(\eta))K_t^\alpha (A_t H_t)^{1-\alpha} \quad (1)$$

байна.

Энд, $N_t h_t = H_t, K_{t+1} = (1 - \delta)K_t + I_t$ байна. (1) тэгшитгэлийн “Solow”-ын үлдэгдлийг бичвэл

$$\begin{aligned} d\ln(Y_t) - d\ln(H_t) &= \alpha \\ &\cdot [d\ln(K_t) \\ &- d\ln(H_t)] + R_t \end{aligned} \quad (2)$$

болно.

$$\text{Энд, } R_t = \frac{A_t}{Y_t} \frac{\partial Y}{\partial A} \frac{\dot{A}}{\dot{A}} + \ln(e^{(-\eta/i)}) =$$

$$\frac{A_t}{Y_t} \frac{\partial Y}{\partial A} \frac{\dot{A}}{\dot{A}} - \frac{\eta}{i} \text{ байна.}$$

Авлигын өсөлтөд үзүүлэх сувгийн механизмууд

1990-ээд оны эхэн үеэс эхлэн авлигын тархалт болон түүний шалтгаан, үр дагаврыг судлах сонирхол нэмэгдэж эхэлсэн. Энэ нь Төв болон Зүүн Европын орнуудад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт


шилжих, мөн хөгжиж буй орнуудад худалдаа, хөрөнгийн хөдөлгөөнийг либералчлах үйл явцтай зэрэгцэн өрнөсөн.

Неоклассик эдийн засгийн онолд зах зээлийг дэмжих нь институтийн үйл ажиллагааг урьдчилан таамаглаж, үүний дагуу үнэ нь эдийн засгийн агентуудын хүлээлт, шийдвэрт нөлөөлөх замаар оновчтой тэнцвэрийг бий болгоно хэмээн найдаж байсан. Гэвч төрийн институтийн (албан ёсны болон албан бус дүрэм, норм, зөрчлийг шийдвэрлэх зохицуулалт) чанар нь эдийн засгийн агентуудын хүлээлт, урамшуулах хөшүүрэг, тэдгээртэй холбогдох зардлын бүтцэд дээр мөн нөлөөлдөг. Институтийн чанар муу байх нь Засгийн газрын хяналт, хөндлөнгөөс оролцоогүй байхад ч үнийн дохио гажуудалгүй үед хүртэл оновчгүй тэнцвэрт байдалд хүргэж болзошгүй (Acemoglu et al., 2004; North, 1990; Rodrik, 1999; Rodrik et al., 2004).

Засаглалын институтийн ач холбогдлыг Адам Смит 1776 онд хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэрээр *"тодорхой хэмжээний шударга засаглалд итгэл байхгүй бол худалдаа, үйлдвэрлэл хөгжихгүй"* гэж үзсэн (Smith, 1976). Түүний *"Улс үндэстний баялгийн мөн чанар, учир шалтгааныг шинжлэхүй"* номд тэрээр хөрөнгө оруулалтын хэмжээ болон эдийн засгийн өсөлтийн ялгааг хууль дээдлэх болон өмчийн эрх зэрэг институтийн чанарын ялгаатай холбон тайлбарласан.

Дуглас Нортын 1990 онд хэвлэгдсэн ном болон 1994 онд нийтлэгдсэн өгүүлэл нь институт нь нийгмийн хөшүүргийн бүтцийг хэрхэн бүрдүүлдэг, мөн эдийн засгийн өсөлтийн голлох бүтээгч болж чаддагийг харуулсан (North, 1990, 1994).

Зураг 6. Авлига ба өсөлтийн хоорондын харилцан хамаарал



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Эдийн засгийн өсөлт дэх авлигын нөлөөг судлах нь эдийн засаг дахь төрийн институтийн үйл ажиллагааг сайжруулах чухал ач холбогдолтой юм. Учир нь авлига нь төрийн институтийн чанар муутай байдлын шалтгаан, илрэл мөн бөгөөд эдийн засгийн шийдвэр гаргахтай холбоотой бодит өртөг, түүнээс бий болох үр өгөөжийг бууруулдаг.

Авлига нь эдийн засгийн өсөлтөд хэд хэдэн сувгаар нөлөөлдөг (Зураг 3). Үүнд: *Улсын төсвийн хөрөнгө оруулалт, засгийн газрын зарцуулалтад нөлөөлөх:*

- Авлига нь эдийн засаг, нийгмийн өгөөж өндөртэй төслөөс илүү улс төрийн өгөөж өндөртэй төслийг сонгох хандлагыг нэмэгдүүлдэг.
- Санхүүгийн эх үүсвэрийг томоохон, хөрөнгө их шаардсан төслүүдэд хэт төвлөрүүлснээр эдийн засгийн тогтворгүй байдал, урт хугацааны өсөлт буурах шалтгаан болдог.

Хүмүүн капиталын хувийн хөрөнгө оруулалт:

Авлигын нөхцөлд мерит тогтолцоо бүхий институтийн үйл ажиллагаа алдагдаж, ур чадвар, чадамж, бүтээмжийн хоорондын уялдаа холбоо сулрах хандлагатай болдог. Үүний улмаас хүмүүн капиталд оруулах хөрөнгө оруулалтын хөшүүрэг багасаж, эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх хандлагатай байдаг.

Хувийн хөрөнгө оруулалт:

Хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх, үйлдвэрлэлийн зардал өсөх, хөрөнгө оруулалтын өгөөжийн тодорхойгүй байдал нэмэгдэх зэрэгт авлига өндөр нөлөөтэй байдаг.

Авлигын байдал ба өсөлт:

Судалгааны үндсэн загвар нь институтийн авилгаас үүдэлтэй зардал нь *үндсэн-агентуудын (principal-agent)* асуудал гэж үздэг. Авлигын түвшин нь улс орнуудын болон тухайн улс орны улс төр, нийгэм эдийн засаг, соёлын орчин нөхцөлөөс шалтгаалан өөр өөр байдаг.

Эконометрикийн загварын тавил

Эконометрик загварын параметрийн үнэлгээ хийхийн тулд $e^{(\eta/i)}$ функцийг шугамчлах хэрэгтэй. Solow-ын үлдэгдлийн тасралтай хэлбэрээр бичвэл,

$$\Delta \ln(Y_t) - \Delta \ln(H_t) = \alpha \cdot [\Delta \ln(K_t) - \Delta \ln(H_t)] + R_t \quad (3)$$

болно. Үүнийг хамгийн бага квадратын арга (ХБКА)-аар үнэлсний дараа үлдэгдэл буюу R_t -г авлигын индексээр ХБКА-аар үнэлнэ.

$$R_t = k - \frac{\eta}{i_1} + \varepsilon_t \quad (4)$$

Энд $\varepsilon_t = \frac{A_t \partial Y}{Y_t \partial A} - k$ байна.

Ш.ТООН ӨГӨГДӨЛ БА ЭМПИРИК СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Шинжилгээг хийхдээ 2000-2024 оны жилийн давтамж бүхий 24 жилийн макро эдийн засгийн тоон өгөгдөл, мөн 2004-2024 оны авлигын индекс ашигласан болно. Бид тоон өгөгдлийг засварлахдаа капиталын эхний түвшнийг *penn-table*¹-ээс авсан ба ажлын хоногийг 252 хоног, ажиллах цагийг 8 цаг гэж авав.

Хүснэгт 6. Дескриптив буюу тодорхойлогч статистик шинжилгээний үр дүн

| | K_t | INV_t | H_t | Y_t | η_t |
|--------------------|----------|----------|-----------|----------|-----------|
| Mean | 651627.5 | 71435.5 | 1087644 | 197906.3 | 33.15 |
| Median | 638741.9 | 64867.61 | 1056441 | 212356.2 | 34 |
| Maximum | 1299000 | 145806.2 | 1355667 | 421356.8 | 39 |
| Minimum | 275818.7 | 12871.94 | 808990 | 51251.26 | 27 |
| Std. Dev. | 331730.3 | 43506.05 | 150821.5 | 112280 | 4.2087 |
| Skewness | 0.376833 | 0.246936 | -0.072113 | 0.336726 | -0.151035 |
| Kurtosis | 1.848777 | 1.723919 | 2.08682 | 2.072049 | 1.628851 |
| Jarque – Bera (JB) | 1.972215 | 1.950304 | 0.89031 | 1.369407 | 1.642746 |
| Probability | 0.373026 | 0.377135 | 0.640725 | 0.50424 | 0.439827 |
| Observations | 24 | | | | 21 |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Капитал, хөрөнгө оруулалт, дотоодын нийт бүтээгдэхүүн нь сая төгрөгөөр (2015 оны үнээр) ба H_t нь сая цагаар, авлигын индексийн 100-д хуваан үнэлэв.

¹Penn World Tables нь Пенсильванийн их сургуулийн Роберт Саммерс, Алан Хестон нар, Ирвинг Кравис нарын хамт бүтээл бөгөөд бодит үндэсний тооцооны өгөгдлийн сан юм. Улс орон бүрийн үндэсний тооцоог эхэндээ тухайн орны өөрийн мөнгөн дэвсгэртээр тооцдог байсан бол хэрэглээний үнийн индексийг ашиглан нийтлэг валют

(АНУ-ын доллар) дээр хөрвүүлж, бодит үндэсний тооцоог гаргасан байдаг. Уг өгөгдөл нь улс орнуудын Дотоодын Нийт Бүтээгдэхүүнийг (ДНБ) харьцуулахад, түүнчлэн хөгжлийн болон эдийн засгийн өсөлтийн талаарх бүхий л төрлийн судалгаанд үнэлж баршгүй ач холбогдолтой сан юм.

Хүснэгт 7. Solow-ын үлдэгдлийн үнэлгээний үр дүн

Dependent Variable: Y_SOLOW
 Method: Least Squares
 Date: 05/29/25 Time: 00:47
 Sample: 2001 2024
 Included observations: 24
 HAC standard errors & covariance (Bartlett kernel, Newey-West fixed
 bandwidth = 3.0000)

| Variable | Coefficient | Std. Error | t-Statistic | Prob. |
|--------------------|-------------|-----------------------|-------------|-----------|
| X_SOLOW | 0.977847 | 0.176898 | 5.527748 | 0.0000 |
| R-squared | 0.034302 | Mean dependent var | | 0.066270 |
| Adjusted R-squared | 0.034302 | S.D. dependent var | | 0.079641 |
| S.E. of regression | 0.078263 | Akaike info criterion | | -2.216713 |
| Sum squared resid | 0.140877 | Schwarz criterion | | -2.167628 |
| Log likelihood | 27.60056 | Hannan-Quinn criter. | | -2.203691 |
| Durbin-Watson stat | 1.489357 | | | |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Хүснэгт 8. Эцсийн үнэлгээний үр дүн

Dependent Variable: R
 Method: Least Squares
 Date: 05/29/25 Time: 00:52
 Sample: 2004 2024
 Included observations: 21

| Variable | Coefficient | Std. Error | t-Statistic | Prob. |
|--------------------|-------------|-----------------------|-------------|-----------|
| n | -0.008040 | 0.003880 | -2.072161 | 0.0521 |
| C | 0.284903 | 0.129535 | 2.199431 | 0.0404 |
| R-squared | 0.184334 | Mean dependent var | | 0.018423 |
| Adjusted R-squared | 0.141404 | S.D. dependent var | | 0.076824 |
| S.E. of regression | 0.071185 | Akaike info criterion | | -2.356668 |
| Sum squared resid | 0.096280 | Schwarz criterion | | -2.257189 |
| Log likelihood | 26.74501 | Hannan-Quinn criter. | | -2.335078 |
| F-statistic | 4.293851 | Durbin-Watson stat | | 1.996221 |
| Prob(F-statistic) | 0.052102 | | | |

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

$f(\eta) = 1 - e^{(-\eta/i)}$ орлуулвал $f(\eta) = 1 - e^{(-\eta/0.00804)}$ болно. Монгол улсын авлигын индекс нь дунджаар 33.15 байна үүнийг орлуулбал $(1 - f(\eta)) = e^{(-0.00804\eta)}$ нь 77% гарч байна. Үүнээс дүгнэхэд хэрэв Монгол улс авлигагүй байсан бол дунджаар одоогийн

дотоодын нийт бүтээгдэхүүний 23%-иар өндөр байжээ.

Авлига нь эдийн засгийн хөгжилд хэрхэн сөргөөр нөлөөлж байгааг Монгол Улсын баримт дээр судлах нь авлигын эсрэг бодлого

боловсруулах, хэрэгжүүлэх чухал үндэслэл болж байна. Байгалийн баялаг ихтэй хөгжиж буй орны хувьд Монгол Улс нь авлигын өндөр түвшнээс үүдэлтэй олон сөрөг нөлөөлөлтэй тулгарч байгаа бөгөөд эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш бус байдал, засаглалын чанар зэрэг олон салбарт сөрөг үр дагаврыг бий болгож байна.

ОУВС-гийн судалгаагаар, авлига багатай орнуудын татварын орлого нь авлига ихтэй орнуудтай харьцуулахад ДНБ-ий 4 хувиар илүү байдаг нь тогтоогдсон. Энэ нь авлига улсын санхүүгийн чадавхыг бууруулж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг болохыг харуулж байна (Mauro, 2019). Авлигын түвшин нэг нэгжээр нэмэгдэхэд, үйлдвэрлэлийн бүтээмж ДНБ-ий 4 хувиар буурч, жил бүрийн цэвэр капиталын урсгал ДНБ-ий 0.5 хувиар буурдаг болохыг тогтоосон. Энэ нь авлига нь хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн үр ашигт сөргөөр нөлөөлдөг болохыг илтгэнэ (Lemke, 2014). Түүнчлэн, 1999-2004 оны хоорондох судалгаагаар, авлигын индекс нэг нэгжээр нэмэгдэхэд, нэг хүнд ногдох ДНБ-ий жилийн өсөлт 1.7 хувиар буурдаг болохыг тогтоосон. Энэ нь авлига нь эдийн засгийн өсөлтийг сааруулдгийг дахин баталсан.

Дээрх судалгаа болон сэдвийн судлагдсан байдал хэсэгт дурдагдсан олон улсын болон дотоодын авлигын чиглэлээр бичигдсэн эмпирик судалгааны үр дүн нь энэхүү Монгол Улсын эдийн засагт авлигын үзүүлэх нөлөөллийг тооцсон судалгааны дүгнэлттэй нийцэж байгаа бөгөөд авлига нь эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт, институтын чанарт сөргөөр нөлөөлдөг болохыг нотолж байна. Иймд засаглалын ил тод байдал, баялгийн шударга хуваарилалт, авлигын эсрэг бодлогыг сайжруулах нь эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал ач холбогдолтой юм.

IV. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар Монгол Улсын нөхцөлд эдийн засгийн өсөлтөд авлига хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохыг зорьсон бөгөөд үйлдвэрлэлийн функц дээр суурилсан эконометрикийн загварыг ашиглаж параметрийн үнэлгээг хийв. “*Transparency International*” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг авлигын төсөөллийн индексээр манай орон 2018 оноос тасралтгүй бууралттай муу үнэлгээ авч, дэлхийн дундаж утгаас доогуур гарсан байна. Судалгааны үр дүнгээр Монголын нөхцөлд одоогийн авлигын түвшнээс үүдэлтэй ДНБ дэх алдагдсан боломжийн өртөг 23 хувь гэж гарсан ба энэ нь Монголын эдийн засаг одоогийн түвшнээс 23 хувиар өсөх потенциал байсныг илтгэж байна. Цаашид албан бус эдийн засгийг хэмжих, авлигыг төрийн болон хувийн секторын аль ч түвшинд бууруулахад анхаарах, асуудлын шийдлийг эрэлхийлсэн бодлогыг боловсруулж ажиллах шаардлагатай байна. Албан бус эдийн засгийг бууруулах, авлигын индексийг сайжруулах хүрээнд дараах алхмыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Төрийн институтын үйл ажиллагааг бэхжүүлэх: Төрийн байгууллагуудын хариуцлагын тогтолцоог сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар авлигын эрсдэлийг бууруулахад онцгой анхаарах шаардлагатай.
2. Эдийн засгийн реформ хийх: Авлигын шалтгаан болсон хүнд суртал, хууль бус үйлдлийг бууруулах зорилгоор эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг цогц байдлаар хэрэгжүүлэх.
3. Олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх: Иргэдийн оролцоог хангах замаар төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг дэмжих, олон нийтийн хяналтын механизм бий болгох.

4. Олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх: Авлигын төсөөллийн индекс өндөр буюу авлига хамгийн бага гэх үнэлгээ бүхий Скандиновын орнууд, Шинэ Зеланд, Сингапур зэрэг орнуудын шилдэг, сайн туршлагыг нутагшуулах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар авлигын эсрэг бодлогыг боловсронгуй болгох.
5. Төрийн хяналтын тогтолцоог сайжруулах: Авлигын улмаас бий болсон алдагдлыг багасгах зорилгоор аудит, хяналтын байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Ашигласан материал

- Acemoglu, D., Autor, D. H., & Lyle, D. (2004). Women, war, and wages: The effect of female labor supply on the wage structure at midcentury. *Journal of Political Economy*, 112(3), 497–551. <https://doi.org/10.1086/383100>
- Aidt, T. S. (2009). Corruption, institutions, and economic growth. *World Development*. <https://doi.org/10.1093/oxrep/grp012>
- Antunes Cavalcanti T., A. (2003). Entrepreneurship and corruption: Informal sector linkages. *Economic Letters*. <https://doi.org/10.1016/eolet.2003.98765>
- Arbex, M., Correa, M., & Magalhaes, M. (2025). The economic implications of corruption dynamics”. *Economics Bulletin*, 45(1), 418–433.
- Bank, W. (2020). Corruption and its Impact on Economic Development. *World Bank Publications*.
- Blackburn et al., K. (2006). Corruption and development: A theoretical perspective. *Economic Development Journal*. <https://doi.org/10.1016/edj.2006.12345>
- Blackburn Powell J., K. (2011). Corruption and economic growth: A dynamic analysis. *Journal of Economic Studies*. <https://doi.org/10.1108/jes.2011.54321>
- Casals & Associates, I. (2005, August 31). *МОНГОЛ УЛС ДАХЬ АВИЛГАЛЫН БАЙДАЛД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ*. USAID. https://pdf.usaid.gov/pdf_docs/Pnade596.pdf
- Choi, J. P., & Thum, M. (2004). The economics of repeated extortion. *Rand Journal of Economics*, 203–223. <https://doi.org/10.2307/1593688>
- Company, M. &. (2018). The Economic Cost of Corruption. *McKinsey Insights*.
- Cooray Schneider F., A. (2018). Corruption and economic growth: Sand the wheels hypothesis. *Public Choice*. <https://doi.org/10.1007/pc.2018.56789>
- Farooq et al., M. (2013). Corruption dynamics in macroeconomic models. *Economic Modelling*. <https://doi.org/10.1016/em.2013.98765>
- Fund, I. M. (2019). Economic Consequences of Corruption. *IMF Working Papers*.
- Huntington, S. (2006). Political order in changing societies. *Nan*. <https://doi.org/nan>
- International, T. (2022). Corruption Perceptions Index 2022. *Transparency International Reports*.
- Kato Sato T., S. (2015). Grease the wheels hypothesis in weak governance settings. *Economic Research Journal*. <https://doi.org/10.1234/erj.2015.12345>
- Kaufmann, D., & Kraay, A. (2019). Governance Indicators and Economic Development. *World Bank Policy Research Working Papers*.
- Leff, N. (1964). Economic development through bureaucratic structures. *American Economic Review*. <https://doi.org/10.1177/000276426400800303>
- Lemke, T. (2014). *The impact of corruption on growth and inequality*. Policy Commons; Transparency International.
- Lui, F. (1985). An equilibrium queuing model of bribery. *Journal of Political Economy*. <https://doi.org/10.1086/261329>
- Mauro, P. (1995). Corruption and growth. *Quarterly Journal of Economics*. <https://doi.org/10.2307/2946696>
- Mauro, P. (2019). The True Cost of Global Corruption. *IMF Finance & Development*, 56(3). <https://www.imf.org/en/Publications/fandd/issues/2019/09/the-true-cost-of-global-corruption-mauro>

- Murphy Shleifer A. Vishny R., K. (1991). The allocation of talent: Implications for growth. *Quarterly Journal of Economics*. <https://doi.org/10.3386/w3530>
- Murphy Shleifer A. Vishny R., K. (1993). Why is rent-seeking so costly to growth? *American Economic Review*. <https://doi.org/10.2307/aer.1993.76543>
- Něemec et al., J. (2021). DSGE models of corruption and informal sector linkages. *Journal of Economic Theory*. <https://doi.org/10.1016/j.jet.2021.54321>
- North, D. C. (1990). Institutions, institutional change and economic performance. *Cambridge University*. <https://doi.org/10.1017/CBO9780511808678>
- North, D. C. (1994). Economic performance through time. *The American Economic Review*, 84(3), 359–368.
- OECD. (2018). Corruption in Extractive Industries: Impacts on Economic Development. *OECD Reports*.
- Pellegrini Gerlagh R., L. (2004). Corruption's effect on growth and institutional quality. *Public Choice*. <https://doi.org/10.1111/j.0023-5962.2004.00261.x>
- Rodrik, D. (1999). Where did all the growth go? External shocks, social conflict, and growth collapses. *Journal of Economic Growth*, 4, 385–412. <https://doi.org/10.1023/A:1009863208706>
- Rodrik, D., Subramanian, A., & Trebbi, F. (2004). Institutions over geography and integration in economic development. *Journal of Economic Growth*, 9, 131–165. <https://doi.org/10.1023/B:JOEG.0000031425.72248.85>
- Smith, V. L. (1976). Experimental economics: Induced value theory. *The American Economic Review*, 66(2), 274–279.
- Svensson, J. (2003). Who must pay bribes and how much? Evidence from a cross section of firms. *The Quarterly Journal of Economics*, 118(1), 207–230. <https://doi.org/10.1162/00335530360535180>
- UNDP. (2014, October 15). “Авлигын эсрэг нүб-ын конвенцийн ii бүлгийн (урьдчилан сэргийлэх арга хэмжээ) хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах.” UNDP.
- Б.Ариун-Эрдэнэ. (2008). What are causes and consequences of corruption in Mongolia? *Эдийн засаг: Онол, Практик*, 19(1), 5–29.
- Б.Соёлмаа. (2019). Авлига болон хүнд суртлын орлого хуваарилалтанд үзүүлэх нөлөө. *Эдийн засаг: Онол, Практик*, 32(1), 1–24.
- Д.Жаргалан. (2011). Монгол улсын авлигыг хэмжих оролдлогууд ба монголын авлигын индексийн судалгаа, түүний ач холбогдол. *Эдийн засаг: Онол, Практик*, 28(3), 31–37.
- Ж.Төртогтох, Д.Оюунчимэг, & Ч.Өлзийсайхан. (2007). Монгол дахь авилгалын түвшинд нөлөөлөгч хүчин зүйлс: баримт бичгийн ба тоон судалгааны анализ. *Политологи*, 3, 85–100. <https://doi.org/10.22353/ps.v3i281.2440>
- МУИС-ийн Орхон салбар сургууль. (2014, March 15). *Авлигын хандлагын судалгаа*. Орхон Аймгийн ЗДТГ.
- УИХ. (2006). Авлигын тухай хууль. In *legalinfo*.
- ШУА-Хэл зохиолын хүрээлэн. (2015). *Монгол хэлний их тайлбар толь*. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар .